

ӨРХ, ГЭР БҮЛИЙН ОРЛОГОД НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

*Даваагийн Намжил, (PhD), МУИС-БС-ийн Санхүүгийн тэнхим, дэд профессор
Пүрэвийн Баянсан, МУИС-БС-ийн Санхүүгийн тэнхим, ахлах багш, докторант*

Хураангуй

Судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын өрх, гэр бүлийн орлогод нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэх үүргийг илрүүлж, иргэдийн цалин, хөдөлмөрийн орлогоос бүрдүүлсэн нийгмийн даатгалын сангийн менежментийг нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн тоон мэдээлэл дээр шинжлэн судлах явдал юм.

Энэхүү судалгаагаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, түүнийг хаана, хэрхэн яаж байршуулж, сангийн менежментийг хэрхэн хийж буйг эрх зүй, санхүүгийн менежмент талаас нь судалж дүгнэлт өгсөн болно. Судалгааны үр дүнгээр нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкны хадгаламж, харилцах дансанд байршуулж хүүний орлогоор арвижуулж байгаа ч тэр нь засгийн газрын үнэт цаасны хүүтэй харьцуулахад бага, үр ашиг муутай, эрсдэл ихтэй байгаа нь тогтоогдлоо.

Засгийн газар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг олон улсын жишигт нийцүүлж өрх, гэр бүлийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор өрхийн хэрэгцээнд хамгийн бага хүүтэй зээл олгох, Засгийн газар, төв банк, олон улсын зах зээлээс үнэт цаас худалдан авах замаар хөрөнгийг арвижуулахад зарцуулбал санхүү-мөнгөний эрүүл зөв урсгал бүрдүүлэх боломжтойг зөвлөмж болгож байна.

Түлхүүр үгс: Нийгмийн даатгал, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хүү, засгийн газрын үнэт цаасны хүү

Abstract

The study aims to investigate the role of the social insurance fund in Mongolian household's income and to analyze social insurance funds management that consists of citizens' wages based on the social insurance fund surplus data. Accordingly, this study examined and concluded the distribution and management of social insurance fund's surplus from legal and financial management perspectives. The findings reveal that even though social insurance fund's surplus is deposited into commercial bank accounts to earn an interest income, it was found to be of higher risk and as inefficient comparing to the sovereign bond rate.

The Government for the purposes of aligning the social insurance fund surplus with the international standard and improving household income, is required to provide cheaper consumer loan while purchasing securities collectively with the Central bank from the international financial market. As a result, the healthy system of financial and money market can be ensured.

Key words: social insurance, social insurance fund's surplus, interest rate, Yield of Government Securities

1. УДИРТГАЛ

Аливаа улсын хөгжлийн түвшингээс үл хамааран оршин тогтнох үндэс бол өрх гэр бүл мөн. Манай орны хувьд сүүлийн жилүүдэд өрх, гэр бүлийн талаар нийгэм, эдийн засгийн тодорхой үзүүлэлтээр судалгаа хийгдэж байгаа боловч нийт улсыг хамруулан өрхийн орлого, зарлагын бүтэц, бүрэлдэхүүн, орлогын бууралт, бүтцийн чанарын өөрчлөлт, шалтгаан, үр дагавар, дүгнэлт өгөх чиглэлээр иж бүрэн судалгааны ажил үгүйлэгдэж байна.

2010 оноос өнөөдрийг хүртэл Засгийн газраас

явуулсан санхүү-мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдэд өрх, гэр бүлийн орлого буурах, хэрэглээний бүтэц өөрчлөгдөх, төлбөрийн чадвар огцом буурахад шууд нөлөө үзүүлж ирлээ.¹³ Төсөв, мөнгөний бодлогын алдаатай шийдвэрүүд нь нийт эдийн засагт үнийн өсөлт бий болгож, төгрөгийн ханш буурах, ажлын байр хумигдах, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг зогсоох зэрэг сөрөг үр дагаварт хүргэсэн.

2012-2016 оны хооронд төгрөгийн ханш 75¹⁴ хувиар суларч, үнийн өсөлт 15 хувиас илүү нэмэгдсэн юм.

¹³ Болдбаатар.Д., “Мөнгөний бодлогын хэрэгжилт, сургамж”, Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулганд тавьсан илтгэл, Өнөөдөр сонин, № 014(6307).

¹⁴ 2018 оны мөнгөний бодлого (баримт бичиг), 2018 оны Төсвийн хууль

Энэ хугацаанд төгрөгийн ханшны уналттай харьцуулахад нийгмийн үйлчилгээний ажилтны нэрлэсэн цалин 30-40 хувиар буурчээ.¹⁵

Нийгмийн үйлчилгээний салбарын ажилтнуудын (эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, спорт гэх мэт) цалинг инфляцийн өсөлт, төгрөгийн ханшны сулралтай уялдуулан 30-40 хувиар нэмэгдүүлэхэд 2018 оны төсвийн бодлого чиглэгдэх ёстой. 2017 оны байдлаар Монгол улсад 869,849 өрх байгаагийн 40 хувь¹⁶ нь ажилгүй, ядуу, орлого багатай нийгмийн ямар нэг халамж үйлчилгээ шаардсан төсвийн бодлого чиглэгдэх ёстой зорилтот гэр бүлд тооцогдож байна.

Орон бүр хөгжлийн түвшингээс үл хамааран нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг өрхийн орлогын ялгааг бууруулах, ядуу, эмзэг бүлэгт үзүүлэх санхүүгийн тусламж хэлбэрээр зарцуулж байдаг. Манай улс нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг төсвийн хуулийн дагуу орлого багатай, ядуу өрх гэр бүлд зориулж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулж байна.

Судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын өрх, гэр бүлийн орлогод нийгмийн даатгалын

сангийн гүйцэтгэх үүргийг илрүүлж, иргэдийн цалин, хөдөлмөрийн орлогоос бүрдүүлсэн нийгмийн даатгалын сангийн менежментийг нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн тоон мэдээлэл дээр шинжлэн судлах явдал юм. Энэхүү судалгаагаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, түүнийг хаана, хэрхэн яаж байршуулж, сангийн менежментийг хэрхэн хийж буйг эрх зүй, санхүүгийн менежмент талаас нь судалж дүгнэлт өгсөн болно.

2. ҮНДСЭН ХЭСЭГ

Засгийн газраас өрх, гэр бүлийн орлого бүрдүүлэхэд улсын төсвийн нийгмийн даатгал, нийгмийн халамж, эрүүл мэндийн даатгалын сангуудаар дамжуулан төрөл бүрийн үйлчилгээг үзүүлж байна. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө 2017 онд 570.2 тэрбум төгрөг, 2018 онд 609.8 тэрбум төгрөг болж өссөн бол нийгмийн халамжийн сангийн хөрөнгө 2017 онд 407.2 тэрбум, 2018 онд 467.7 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө 2017 онд 316.8 тэрбум төгрөг, 2018 онд 341.3 тэрбум төгрөгт хүрч тус тус өссөн байна.¹⁷

Засгийн газрын улсын төсвийн тусгай сангуудын зардлын эх үүсвэрийг харуулбал:

Хүснэгт 1. Засгийн газрын улсын төсвийн тусгай сангуудын зардлын эх үүсвэр (тэрбум төг)

№	Үзүүлэлт	2017	Зардлын эх үүсвэр	
			Улсын төсөв	Өөрийн орлого
1	Нийгмийн даатгалын сан	1808.2	609.8 (33.7%)	1198.4 (66.3%)
2	Нийгмийн халамжийн сан	648.0	648.0 (100 %)	-
3	Эрүүл мэндийн даатгалын сан	341.3	-	341.3 (100 %)

Тэмдэглэл: Нийт дүнд эзлэх хувийн жинг хаалтанд харуулав.

Өрх гэр бүлд нийгмийн даатгал, халамж, эрүүл мэндийн чиглэлээр үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээнд төсвөөс зарцуулагдах хөрөнгө нэмэгдэхээс гадна ажил олгогч, ажиллагсдын эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлээс өөрийн орлого бүрдэж байна.

2017 онд Дэлхийн банк болон Үндэсний статистикийн хорооны гаргасан судалгаагаар ядуурлын түвшин 29.1 хувь¹⁸ болж 2012 оноос 8.1 хувиар өссөн байна. Засгийн газар төсвийн зөв бодлого хэрэгжүүлэх, өрх гэр бүлийг ядуурлаас гаргах, ажил эрхлэлт,

¹⁵ Ган-Очир.Д., “ 2018 оны эдийн засаг, санхүүгийн салбарын төлөв, сорилтууд”, Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулганд тавьсан илтгэл, Өнөөдөр сонин, № 014(6307).

¹⁶ 2018 оны Төсвийн хууль, хуудас 255

¹⁷ Монгол Улсын 2018 оны төсвийн баримт бичиг, УБ 2017, хуудас 331.

¹⁸ Дэлхийн банк, Үндэсний Статистикийн Хороо, Нийт өрхийн ядуурлын түвшинд хийсэн судалгааны тайлан, УБ, 2018 он.

орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд зорилтот гэр бүлд чиглэсэн дараах хөтөлбөр хэрэгжүүлэхээр болов. Үүнд:

- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид нийт 135.0 мянган хүүхэд хамарч 81.0 тэрбум төгрөг,
- Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмжид 16500 хүн хамрагдаж 15.8 тэрбум төгрөг зарцуулна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2018 онд 65.8 тэрбум төгрөг зарцуулна.
- Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрт 2018 онд 8.5 тэрбум төгрөг зарцуулахаар байна.

Монгол улсын хэмжээнд зөвхөн хүүхэд асрах, өрх толгойлсон 151500 өрх гэр бүл хамрагдахад 96.8 тэрбум төгрөг зарцуулна. Өрх гэр бүлийн орлогыг бүрдүүлэхэд тодорхой дэмжлэг болж буй хүүхдийн мөнгө тэтгэмжийг 2018 онд үргэлжлүүлэн 684000 хүүхдэд 164.1

тэрбум зарцуулахаар болов. Засгийн газар 2018 ондахмаднастанд “Насныхишиг” олгоход 121900 өрх хамрагдаж 20.0 тэрбум төгрөг зарцуулна. Олон улсын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”¹⁹-ийн хүрээнд бага орлоготой 54000 өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, хүнсний талон олгоход 16.2 тэрбум төгрөг төсвөөс зарцуулж байна.

Засгийн газраас өрх, гэр бүлийн орлогыг бүрдүүлэхэд төсвийн бодлогоор дамжуулан тодорхой хөтөлбөр хэрэгжүүлж, ядуурал, ажилгүйдэл, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлж байгаа боловч цаашид нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл хөрөнгийн хуваарилалтыг оновчтой болгон өрх гэр бүлийн ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглүүлэх нь зөв алхам болно.


2012-2016 оны байдлаар нийгмийн даатгал сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд тодорхой хугацаатай байршуулсан байдлыг харуулбал:

Хүснэгт 2. НДС-ийн орлогын бүрдүүлэлт, оны эцэст (тэрбум төг)

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийгмийн даатгалын сангийн нийт орлого	1,071.6	1,283.0	1,394.9	1,480.5	1,809.9
<u>Үүнээс:</u>					
НДС-ийн чөлөөт үлдэгдлийг банкинд байршуулсан дүн	163.0	245.0	532.0	467.0	716.8
НДС-ийн чөлөөт үлдэгдлийг банкинд байршуулсны хүүгийн орлого	10.0	18.1	44.5	56.0	78.1

Эх сурвалж: ЭМНДЕГ-ын мэдээлэл, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, 2017.

Зураг 1. НДС-ийн чөлөөт үлдэгдлийг банкинд байршуулсны хүү



Эх сурвалж: ЭМНДЕГ-ын мэдээлэл, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, 2017.

¹⁹ ОУВС-ийн ажлын хэсэг ОУВС, Монгол Улсын засгийн газар хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрийн 2019-2020 оны төсвийн үзүүлэлтүүд бодлогын арга хэмжээтэй тохирч буйг дүгнэсэн байна.

Дүн шинжилгээнээс харахад, НДС-ийн чөлөөт үлдэгдлийг банкинд байршуулсан дүн, түүнд бодогдсон хүүний мөнгөн дүн жил тутамд өсөж буй хэдий ч бодит хүүний хувь нь 2016 оны байдлаар буурсан байна. Энэ нь хүүний өсөлтийн хувь нь байршуулж байгаа мөнгөний

дүнтэй шууд порпорциональ бус байгааг илтгэнэ.

Монгол Улсын хэмжээнд 2016 оны мэдээгээр нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл 885.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнийг бүтцээр харуулбал:

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн бүтэц, 2016

Үзүүлэлт	Нийт дүн, тэрбум.төг	Дүнд эзлэх хувь
Нийгмийн даатгалын сангийн үлдэгдэл	885.1	100.0%
<u>Үүнээс:</u> ҮОМШӨ-ний даатгалын сан	335.1	37.9%
Ажилгүйдлийн даатгалын сан	123.8	14.0%
Эрүүл мэндийн даатгалын сан	387.3	43.8%
Тэтгэвэр, тэтгэмжийн харилцах данс	38.9	4.4%

Эх сурвалж: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээс, 2017

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хэрхэн зарцуулах талаар нийгмийн даатгалын тухай хуулийн 11-р зүйлд: “Хуримтлалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бонд болон Монгол банкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлж болно” гэж заасны дагуу (2008 оны 5 дугаар сарын 8-ний өдөр өөрчлөлт орсон) зарцуулж байна.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд байршуулж буй дүн, хүүний хэмжээ, бүтцийн судалгаа

Банкны нэр	Хадгаламж хэлбэрээр байршуулсан хөрөнгө / тэрбум.төг/	Эзлэх хувь, %	Харилцах дансанд байршиж буй хөрөнгө / тэрбум. төг/	Эзлэх хувь, %	Хадгаламжийн хүү / хувиар /	Харилцах-ын хүү / хувиар /
Төрийн	55.0	9.5	28.2	11.2	9.0	5.5
Чингис хаан	48.0	8.3	10.5	4.2	9.0	5.5
Улаанбаатар хотын	133.0	23.1	8.4	3.3	9.0	5.5
Капитал	180.0	31.2	41.0	16.3	9.0	5.5
Капитрон	30.0	5.2	7.5	3.0	9.0	5.5
Голомт	50.0	8.7	10.7	4.3	9.0	5.5
Хаан	6.0	1.0	24.5	9.8	9.0	5.5
ҮХОБ	35.0	6.1	1.4	0.6	9.0	5.5
Худалдаа хөгжлийн	40.0	6.9	6.8	2.7	9.0	5.5
Хас	-	0.0	0.8	0.3	9.0	5.5
Төрийн сан	-	0.0	111.3	44.3	9.0	-
Нийт	577.0	100.0	251.1	100.0		

Эх сурвалж: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээс

2016 оны байдлаар Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хадгаламж болон харилцах дансанд байршуулж байгаагаас үзэхэд хадгаламжийн 31.2 хувийг Капитал банкинд, 23.1 хувийг Улаанбаатар хотын банкинд байршуулсан бол харилцах дансны үлдэгдлийн 16.3 хувийг Капитал, 11.2 хувийг Төрийн банкинд байршуулжээ.

Олон улсын практикт нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл буюу хуримтлалын санг дараах журмаар өсгөн арвижуулдаг. Үүнд:

Нэг. Төрийн мэдлийн хуримтлалын сан хариуцсан компаниар менежмент хийлгэн зах зээлээс баталгаат үнэт цаас худалдан авч хөрөнгийг арвижуулах.

Хоёр. Хуримтлалын сангийн чөлөөт үлдэгдлийг Засгийн газрын болон төв банкны үнэт цаас авч арвижуулж байна.

Манай улсын нийгмийн даатгалын хуулинд арилжааны банкыг оруулсан нь олон улсын жишиг, иргэдийн нийгмийн даатгал дахь тодорхой зориулалттай хөрөнгийг буруу байршуулж, үндсэн хууль, иргэний, эрүүгийн,

бусад хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр болжээ.

Арилжааны банкуудад нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг бага хүүтэй байршуулж, тэр эх үүсвэрээр засгийн газрын үнэт цаас худалдан авч, хүүгийн зөрүүгээр их хэмжээний орлого олж байгааг дараах тоо баримтаас харж болно.

Хүснэгт 5. Арилжааны банкууд дахь нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд байршуулсны хүү, засгийн газрын үнэт цаасны хүүгийн зөрүү

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
НДСЧҮ-ийн арилжааны банкны хадгаламжид байршуулсан дүн /тэрбум.төг/	163.0	245.0	532.0	467.0	577.0*
Засгийн газрын үнэт цаасны жинлэсэн дундаж хүүний хувь	12.95%	9.67%	12.55%	14.83%	16.43%
НДСЧҮ-ийг арилжааны банкны хадгаламжид байршуулсан хүү, хувь	6.13%	7.39%	8.36%	11.99%	9.00%
Хүүгийн зөрүү, хувь	6.82%	2.28%	4.19%	2.84%	7.43%
Хүүгийн зөрүүгээс олох боломжтой байсан орлогын дүн /тэрбум.төг/	11.1	5.6	22.3	13.3	42.8

Эх сурвалж: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээс

Тэмдэглэл: *НДСЧҮ-Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл*

**-2016 оны 10-р сарын байдлаарх дүн*

2016 оны 10-р сарын байдлаар Засгийн газраас арилжааны банкууд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл болох 828 тэрбум төгрөгийг хадгаламж, харилцах дансанд бага хүүтэй байршуулж, энэ эх үүсвэрээр засгийн газрын үнэт цаасыг худалдан авч хүүгийн зөрүүгээс өнгөрсөн жилүүдэд 95 орчим тэрбум төгрөгийн орлого олсон нь олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй харьцуулахад ноцтой зөрчил юм. Иймд Засгийн газар нийгмийн даатгалын хуулинд 2008 онд оруулсан өөрчлөлтийг хүчингүй болгох хэрэгтэй.


Гурав. Австрали, Норвеги, Швед зэрэг хөгжингүй орнуудын туршлагаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээр Төрийн мэдлийн хөрөнгө оруулалтын сан байгуулж гадаад, дотоодын зах зээлээс үнэт цаас, вексель, өрийн бичиг худалдан авч хөрөнгийг арвижуулж, өрх гэр бүлийн орлого нэмэгдүүлэх зорилгоор жил бүр нэг удаагийн мөнгөн урамшуулал олгох, хүү багатай зээлийн үйлчилгээг үзүүлдэг туршлагыг хэрэгжүүлж болно.

Дөрөв. Нийгмийн даатгалын сангийн жил бүрийн үлдэгдэл нэмэгдэж 800 тэрбум төгрөгөөс 1 их наяд төгрөгт хүрч байгаа нь

бага бус санхүүгийн нөөц бүрдэж байгаа тул хөрөнгө оруулалтын төрийн өмчийн сангийн тухай хууль батлан тодорхой зориулалтаар, тухайлбал, тэтгэвэр авагч өрхөд хямд хүүтэй зээл олгох, үнэт цаасны хөрөнгө оруулалт хийх зэрэг арга хэмжээг хуульчилж өгөх нь цаг үеийн асуудал болно.

Тав. Тэтгэвэр авагч нийт өрхийн 80 гаруй хувь нь тэтгэврийн зээлд хамрагдаж тэтгэврийн зээлийн хөрөнгийн 20 хувь нь зөвхөн хүү төлөхөд зарцуулагдаж байгаа нь өрхийн орлого бүрдүүлэлтэд муугаар нөлөөлж байна. Хэрэв нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс бага хүүтэй (жилийн 3 хүртэл хувь) зээл олгох хууль эрх зүйн орчин бүрдвэл тэтгэвэр авагч өрх гэр бүлийн орлого нэмэгдэж, зарлагын хэмжээ 15 хувиар буурах боломжтой болно.

Зургаа. Монгол Улсын тэтгэвэр авагч өрхийн тэтгэврийн орлого нь нийт хэрэглээний зардлын 15 хувьд хүрэхгүй байгаа нь цаашид тэтгэврийн дундаж хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Зураг 2. Хэрэглээнд эзэлж буй хувийн жин, улсын дунджаар, 2016 он

Эх үүсвэр: С.Ф. Родригес. 2017, “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2016 оны үр дүн”, Дэлхийн банк.

Манай улсын өрх, гэр бүлийн нийт хэрэглээнд нийгмийн хамгааллын бүх хөтөлбөр дөнгөж 20 гаруй хувьтай байгаа нь өрхийн орлого бүрдүүлэлтэд онцгой үүрэг гүйцэтгэж чадахгүй байгаагийн нэг баримт юм. Үүнийг дэлхийн банкнаас хийсэн судалгаа нотолж байна.

3. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Засгийн газар өрх гэр бүлийн нийт хэрэглээнд эзлэх нийгмийн хамгааллын зорилтот хөтөлбөрүүдийн хувийн жинг нэмэгдүүлэхэд жил бүр анхаарч, сар тутамд олгох хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Засгийн газар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг олон улсын жишигт нийцүүлж төрийн өмчийн хөрөнгө оруулалтын сан байгуулж үр дүнгээр нь тэтгэвэр авагч болон ядуу өрх гэр бүлд жил бүр урамшуулал олгох эрх зүйн орчин бүрдүүлэх нь зүйтэй.

Засгийн газрын зүгээс орлого бага ядуу өрх, тэтгэвэр авагч өрх гэр бүлд бага хүүтэй зээл олгох замаар тэдний нийт хэрэглээг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлсэнээр ядуурлыг бууруулах боломж бүрдэнэ.

Дэлхийн банкнаас 2016 онд хийсэн судалгааны дүгнэлтээр ядуу, эмзэг өрхөд чиглэсэн нийгмийн шинж чанартай шилжүүлэг олгох нь зөв гэсэн дүгнэлт хийсэн нь хэрэгжүүлэх шаардлагатай нэг арга хэмжээ болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 2017, Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 2017, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах

тухай.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 2017, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 2017, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай.

МУЗГ, 2016, Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

Монгол Улсын Их Хурал, 1994, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, №8.

Монгол Улсын Их Хурал, 2012, Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн мэдээлэл эмхтгэл, №3.

НХХЯ, ЭМНДЕГ, 2017, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, ВСИ хэвлэлийн компани.

УАГ, 2017, Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан.

ҮСХ, 2017, Нийгмийн даатгал, халамж: 2016, судалгааны танилцуулга.

ҮСХ, Статистик мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn.

Сангийн яам, Засгийн газрын үнэт цаасны арилжааны мэдээ, 2012-2016 оны үзүүлэлт.

Родригес.С.Ф., 2017, “Монгол Улсын ядуурлын чиг хандлагад нөлөөлсөн үндсэн хүчин зүйлс (2010-2016)”, Дэлхийн банк.

Родригес.С.Ф., 2017, “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2016 оны үр дүн”, Дэлхийн банк.

Цахим эх сурвалж:

<http://www.mof.gov.mn/>

<http://www.ndaatgal.mn/>

<http://www.parliament.mn/>

<http://www.legalinfo.mn/>